

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН “ТОГТООЛЫН
ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН
ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлснийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, Төсвийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явууллаа.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр нь худалдааны урсгалыг нэмэгдүүлэх, экспортын боломжийг өргөжүүлэх ач холбогдолтой ч тарифын хөнгөлөлт эдлэх барааны жагсаалтад тамхи, тамхин бүтээгдэхүүнийг хамруулсан нь уг бүтээгдэхүүний өртөг буурч, зах зээлийн үнэ хямдрах, улсын төсвийн орлогын тогтвортой байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй тул тамхи, тамхин бүтээгдэхүүнд онцгой албан татварыг хосолсон хэлбэрээр ногдуулах, мөн үнэд суурилсан татварын хувь хэмжээг тодорхойлон зохицуулахаар хууль, тогтоолын төслийг боловсруулсан байна.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг d.parliament.mn цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин онцгой албан татварын хэмжээг одоогийн зах зээлд борлуулагдаж байгаа тамхины үнэтэй уялдуулан тогтоосон эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нэг бүтээгдэхүүнд онцгой албан татварыг хосолсон хэлбэрээр ногдуулах боломжтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Улсын Их Хурлын гишүүд болон Засгийн газраас өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын хуулийн төслүүдэд давхардаж тусгагдсан зохицуулалтыг хэрхэн уялдуулж хэлэлцүүлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн тамхи, тамхин бүтээгдэхүүний онцгой албан татварыг түүнд агуулагдах никотины хэмжээ, нийтийн эрүүл мэндэд нөлөөлөхтэй холбоотой судалгаа, шинжилгээний дүгнэлтийг харгалзан тогтоодог байх, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүдээс өргөн мэдүүлсэн Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд тусгагдсан зохицуулалтуудыг хэрхэн уялдуулах болон тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн тарифыг тэглэсэнтэй холбоотойгоор онцгой албан татварыг хувь тэнцүүлэн ногдуулахдаа Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан тамхины никотины хэмжээтэй уялдуулан ялгавартай тогтоох, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд Евразийн хэлэлцээрийн хүрээнд тамхи, тамхин бүтээгдэхүүний гаалийн албан татварыг тэглэсэнтэй холбоотойгоор онцгой албан татварыг нэмэгдүүлж байгаа нь далд эдийн засгийг үүсгэх эрсдэлтэйг анхааруулж, энэ талаар Засгийн газраас хэрэгжүүлэх хяналтыг сайжруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа байгаль орчин, нийтийн эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй тамхи, тамхин бүтээгдэхүүнд ногдуулах онцгой албан татварын хэмжээг нэмэгдүүлж байгаа нь зүйтэй хэдий ч одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Онцгой албан татварын тухай хуулийн үзэл баримтлалд нийцэх эсэхийг анхаарах нь зүйтэй талаар хэлсэн болно.

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 55.6 хувийн саналаар дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР